



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2020

Э-сонин

2-Р САР

79-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2020.02.29-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	17
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	1,942,978,128.13
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	1,942,978,128.13
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	0
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	23,577,870
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	23,577,870
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	0
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	3,691


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	198
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	170
I ангилал	14
II ангилал	44
III ангилал	140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	57
Үүнээс: Брокер, Дилер	51
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.02.29-ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Ард капитал групп ХХК	16,663,838	775,378,065.89	16,643,883	780,702,871.44	1,556,080,937.33
2	БиДиСек ХК	1,341,639	400,244,498.72	598,711	340,513,073.49	740,757,572.21
3	Голомт Капитал ХХК	2,879,358	199,027,746.48	3,017,957	200,948,210.56	399,975,957.04
4	Стандарт инвестмент ХХК	576,210	68,036,994.98	1,423,557	136,469,901.08	204,506,896.06
5	Ард секюритиз ХХК	540,489	118,609,837.46	323,231	66,880,449.37	185,490,286.83
6	Ти Ди Би Капитал ХХК	310,979	55,889,558.57	259,435	94,819,501.11	150,709,059.68
7	Блүмсбюри секюритиес ХХК	30,842	7,858,785.00	348,859	72,467,067.74	80,325,852.74
8	Новел инвестмент ХХК	64,270	43,976,365.99	31,648	21,317,250.00	65,293,615.99
9	Алекс Капитал ҮЦК	197,642	24,182,624.94	210,038	32,731,463.74	56,914,088.68
10	Зэргэд ХХК	108,912	10,657,350.91	69,736	41,518,835.00	52,176,185.91
11	Бумбат-Алтай ХХК	182,274	31,699,867.56	56,735	20,386,274.19	52,086,141.75
12	Гаули ХХК	183,856	40,728,139.74	43,344	5,482,368.94	46,210,508.68
13	Инвескор капитал ҮЦК	15,296	39,908,939.00	110	290,230.00	40,199,169.00
14	Монгол секюритиес ХК	51,107	31,566,662.75	147	66,150.00	31,632,812.75
15	Лайфтайм инвестмент ХХК	8,961	23,087,005.50	9,200	3,469,205.43	26,556,210.93
16	Таван богд ХХК	1,393	3,613,359.90	32,710	22,336,014.65	25,949,374.55
17	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	20,675	1,213,715.30	180,008	20,856,410.40	22,070,125.70
18	Централ секьюритиз ҮЦК	107,130	9,525,449.70	70,803	11,726,822.70	21,252,272.40
19	Нэйшнл сэкюритис ХХК	0	0.00	7,789	16,618,500.00	16,618,500.00
20	Эм Ай Би Жи ХХК	28,543	11,357,000.00	4,000	352,000.00	11,709,000.00

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.02.29-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	HBO	ХАЙ БИ ОЙЛ	16,630,096	770,103,234	67	51	-21.43
2	APU	АПУ	738,960	463,177,161	668	600	4.57
3	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	3,609,991	186,288,901	53	49	2.25
4	GOV	ГОВЬ	308,544	78,506,855	263	240	-6.13
5	TTL	ТАВАН ТОЛГОЙ	8,446	54,873,345	6,700	6,430	1.85
6	MBW	МОНГОЛ БАЗАЛТ ХК	220,221	54,220,442	264	231	-7.07
7	INV	ИНВЕСКОР ББСБ	17,473	45,679,586	2,692	2,471	0.15
8	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	31,778	39,601,725	1,450	1,002	29.61
9	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	938,082	38,513,581	44	39	-6.98
10	TUM	ТҮМЭН ШУВУУТ	212,884	34,007,223	170	152	1.64
11	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	21,741	32,569,508	1,550	1,470	-4.94
12	MFC	МОНОС ХҮНС	308,668	22,315,294	75	70	-2.03
13	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ	35,893	19,609,590	594	470	14.71
14	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	24,306	15,327,878	650	625	-2.07
15	SUU	СҮҮ	45,315	9,317,863	210	205	0.77
16	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	123,200	9,095,861	78	71	-4.36
17	ITLS	АЙТҮҮЛС	115,784	8,381,703	75	70	1.37
18	ATR	АТАР-ӨРГӨӨ	130	8,190,000	63,000	63,000	4.48
19	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	80	7,173,440	96,000	88,000	-2.91
20	AIC	АРД ДААТГАЛ ХК	8,614	6,086,862	730	700	-2.74



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.02.29-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2020-02-01	2020-02-29		
1	МОНГОЛ ДААТГАЛ	677	214	900	686	320.40
2	ДАРХАН НЭХИЙ	254	12,010	15,790	3,780	31.47
3	ЖЕНКО ТУР БЮРО	60,389	70	91	21	29.99
4	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	31,778	1,003	1,300	297	29.61
5	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	7,075	20	25	5	25.05
6	УБ-БҮК	420	300	370	70	23.33
7	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ	35,893	479	550	71	14.71
8	ШАРЫН ГОЛ	396	1,100	1,255	155	14.09
9	МОНИНЖБАР	1,714	110	120	10	9.09
10	АРИГ ГАЛ	257	3,077	3,300	223	7.25
11	БИ ДИ СЕК	5,427	852	900	48	5.63
12	ОЛЛОО	10	66	69	3	5.00
13	АПУ	738,960	616	644	28	4.57
14	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	3,439	621	649	28	4.54
15	АТАР-ӨРГӨӨ	130	60,300	63,000	2,700	4.48
16	БАЯНТЭЭГ	2	27,500	28,500	1,000	3.64
17	ДӨРВӨН-УУЛ	176	775	800	25	3.23
18	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	36,871	87	89	2	2.32
19	МАНДАЛ ДААТГАЛ	3,609,991	50	51	1	2.25
20	ТАВАН ТОЛГОЙ	8,446	6,490	6,610	120	1.85

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.02.29-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2020-02-01	2020-02-29		
1	УВС ЧАЦАРГАНА	150	330	240	-90	-27.27
2	СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	1,000	66	49	-17	-25.76
3	ХАЙ БИ ОЙЛ	16,630,096	70	55	-15	-21.43
4	АДУУН ЧУЛУУН	757	1,350	1,101	-249	-18.44
5	СИЛИКАТ	473	50	41	-9	-18.00
6	СОР	47	1,150	978	-173	-15.00
7	БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ	5	2,000	1,700	-300	-15.00
8	МОНГОЛ ШИЛТГЭЭН	20	300	255	-45	-15.00
9	МЕРЕКС	1,111	20	17	-3	-14.96
10	СТАНДАРТ НООС	63	280	240	-40	-14.29
11	АГРОТЕХИМПЕКС	5	1,045	900	-145	-13.88
12	БАГАНУУР	761	1,045	910	-135	-12.92
13	ХӨХ ГАН	7,216	80	70	-10	-12.50
14	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1	390	350	-40	-10.22
15	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	358	500	450	-50	-10.00



“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ЗӨВЛӨЖ БАЙНА

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашгийг иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хувьцаанд мөнгөн хөрөнгөөр хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд ногдол ашгийг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгох ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар болсон.

Энэхүү шийдвэр гарсантай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос дараах мэдэгдлийг хийж байна. Үүнд:

1/ Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолоор хувьцаат компаниудын ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох асуудлыг хэлэлцэж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хувьцаат компаниудын ногдол ашгийг зөвхөн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар зуучлуулан тарааж байхыг хувьцаат компаниудын удирдлагуудад даалгасан тул хувьцаа эзэмшигчид өөрийн харилцагч брокероороо дамжуулан ногдол ашгаа авна.

Харин үнэт цаасны дансгүй хувьцаа эзэмшигчдийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компаниудаас сонгон үнэт цаасны дансаа нээх боломжтой.

Хувьцаа эзэмшигч үнэт цаасны дансаа нээлгээгүй байсан ч ногдол ашгийн мөнгөн хөрөнгө “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дээр хадгалагдах бөгөөд ногдол ашгийг хуваарилах ажиллагаа нь **2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэх** тул шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс мөн Монгол Улсын Засгийн газраас хуулийн этгээдүүдийг “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т хэсэгчлэн шилжүүлсэн байгаа энэ үед **өөртөө болон бусдад эрсдэл үүсгэхгүй, хэт яаравчлахгүй байдлаар үнэт цаасны дансаа нээлгэх** ажлаа зохион байгуулах нь зүйтэй.

2/ Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс мөн Монгол Улсын Засгийн газраас хуулийн этгээдүүдийг “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т хэсэгчлэн шилжүүлсэн байгаа энэ үед иргэдийг үнэт цаасны данс нээлгэхийг уриалах, шахааж шаардан олноор нь цуглуулахаас зайлсхийн ажиллахыг нийт үнэт цаасны компаниудад анхааруулж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АЖЛЫН ЦАГИЙН ХУВААРЬТ ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 4 дүгээр тушаалыг тус тус үндэслэн шинэ коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний хүрээнд компанийн ажилтнуудын ердийн ажлын цагийг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс

эхлэн Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал цуцлагдах хүртэлх хугацаанд 1 цагаар богиносгож, 8:30-16:30 цаг хүртэл байхаар зохицуулж, ажлын тусгай горимд шилжүүлэхээр боллоо.

Энэхүү ажлын цагийн хуваарийн өөрчлөлт нь МХБ-ийн арилжааны цагийн хуваарьт нөлөөлөхгүй болно.

БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Нээлттэй хувьцаат компани ногдол ашиг тараах нь тухайн компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх чухал үзүүлэлт төдийгүй, цаашид компанийн талаарх эерэг хүлээлтийг бий болгон хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд түлхэц үзүүлдэг.

Санхүүгийн Зохицуулах Хороо 2020 оны 01 сарын 29-ний өдрийн хуралдаанаар хувьцаат компаниудын ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох асуудлыг хэлэлцэж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хувьцаат компаниудын ногдол ашгийг зөвхөн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар зуучлуулан тарааж байхыг нээлттэй хувьцаат компаниудад үүрэг болгосон билээ.

Иймд компани нь ногдол ашиг тараах болон СЗХ-ны 2020 оны 01 сарын 29-ний өдрийн 28 тоот тогтоолын дагуу ногдол ашгаа зуучлуулан тараах шийдвэр гаргахдаа Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу ногдол ашиг төлөх өдрийг тодорхой нэг өдрөөр тогтоон /улирал, сараар биш/ “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан эхний 2 улиралд багтаан тараахыг уламжилж байна.

Мөн ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллаж, ногдол ашиг хуваарилалтын тайлангаа ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор МХБ-д ирүүлнэ үү.

“ИНВЕСКОР ББСБ” ХК ОЛОН НИЙТЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн биржид 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 18.46 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн “Инвескор ББСБ” ХК нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулсан тухай тайлан ирүүлсэн байна. Үүнд:

- Хэрэглээний зээл - 11.1 тэрбум төгрөг;
- ААН-ын зээл - 4.6 тэрбум төгрөг;
- Иргэдийн бизнесийн зээл - 1.8 тэрбум төгрөг;
- Кредит карт - 0.9 тэрбум төгрөг.



“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦААТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨМЖ МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрээр компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах болсонтой холбогдуулан Монголын хөрөнгийн биржид хандаж, ногдол ашиг авах, үнэт цаасны данс нээлгэх, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг арилжаалах боломжтой эсэх асуудлаар тайлбар, мэдээлэл хүсч байгаа иргэдийн тоо ихээхэн нэмэгдэж байгаатай холбогдуулан дараах мэдээллийг хүргэж байна. Үүнд:

Ногдол ашиг гэж юу вэ?

Ногдол ашиг гэдэг нь компани тайлант хугацаанд олсон ашгаасаа хувьцаа эзэмшигчиддээ тараахыг хэлнэ. Компани ашгаа тараахын оронд шинэ тоног төхөөрөмж худалдаж авах, үйлдвэрлэлээ өргөтгөх зэргээр дотооддоо ашиглаж болох тул компани жил бүр ногдол ашиг тараахгүй байж болно.

Ногдол ашиг авснаар хувьцааны тоо хэмжээнд өөрчлөлт орох уу?

Ногдол ашиг авснаар хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо хэмжээнд өөрчлөлт орохгүй. Зүйрлэж хэлбэл, хүн өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгөө бусдад түрээслүүлснээр түрээсийн орлоготой болох бөгөөд энэ нь тухайн үл хөдлөх хөрөнгөө худалдаж байгаа зүйл биш юм.

Ногдол ашгаа хэрхэн авах вэ?

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр компанийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 төгрөг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд тус компанийн зүгээс ногдол ашгийг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “ҮЦТХТ” ХХК-д байрлах иргэдийн үнэт цаасны дансаар дамжуулан тараах тухай мэдэгдсэн.

Үнэт цаасны данс хэрхэн нээлгэх вэ?

Хэрэв иргэн үнэт цаасны данс нээлгэхийг хүсвэл юуны түрүүнд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн цахим хуудас, “1072 хувьцааны мэдээллийн төв”-ийн цахим хуудас эсвэл 158989 дугаарт регистрийн дугаараа латин үсгээр бичиж илгээснээр өмнө нь үнэт цаасны данс нээлгэж байсан эсэхээ шалгаж болно. Үнэт цаасны данстай бол дахин нээлгэх шаардлагагүй.

Хувьцаа эзэмшигч үнэт цаасны дансаа нээлгээгүй байсан ч ногдол ашгийн мөнгөн хөрөнгө “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дээр хадгалагдах бөгөөд ногдол ашгийг хуваарилах ажиллагаа нь **2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэх** тул шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс мөн Монгол Улсын Засгийн газраас хуулийн этгээдүүдийг “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т хэсэгчлэн шилжүүлсэн байгаа энэ үед **өөртөө болон бусдад эрсдэл үүсгэхгүй, хэт яаравчлахгүй байдлаар үнэт цаасны дансаа нээлгэх** ажлаа зохион байгуулахыг Санхүүгийн зохицуулах хорооноос зөвлөсөн. Үнэт цаасны дансыг 2018 оноос эхлэн цахимаар нээх боломжтой болсон тул иргэд заавал үнэт цаасны компани дээр биеэр очихгүйгээр дансаа нээлгэж болно. Уг дансыг хөрөнгийн

биржид бүртгэлтэй аливаа компанийн хувьцааны арилжаанд оролцох, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн биржид бүртгэгдсэний дараа арилжаалах үед ашиглана. Үнэт цаасны данс нээлгэх компанийг сонгохдоо тус компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх, үйлчилгээний чанар, хүртээмж, үнэ өртөг зэргийг харгалзан үзэж шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Өнөөдрийн байдлаар дараах үнэт цаасны компаниуд цахимаар данс нээх үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

1. “Апекс Капитал ҮЦК” ХХК - <https://dbx.apex.mn/>
2. “Ард Капитал ҮЦК” ХХК - <http://dbx.ardcapital.mn>
3. “Ард Секюритиз ҮЦК” ХХК - <http://ardsecurities.com/>
4. “БиДиСЕК ҮЦК” ХК - <https://reg.bdsec.mn/>
5. “Бумбат Алтай ҮЦК” ХХК - <http://dbx.bumbat.mn/>
6. “Гаули ҮЦК” ХХК - <http://www.gauli.mn/>
7. “Толомт Капитал ҮЦК” – Social Pay
8. “Гүүдсек ҮЦК” ХХК - <https://goodsec.mn/online>
9. “Масдак ҮЦК” ХХК - <http://masdaq.msem.mn/login>
10. “Өндөрхаан ҮЦК” ХХК - <https://undurkhaan.msem.mn/>
11. “ТиДиБи Капитал ҮЦК” ХХК - <https://www.tdbcapital.mn/page/open-brokerage-account>
12. “Стандарт Инвесмент ҮЦК” ХХК - <https://dbx.standardinvestment.mn/>
13. “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК - <https://xacex.tengercapital.mn/>

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаагаа худалдах, өв залгамжлал хийлгэх боломжтой юу?

Одоогоор боломжгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 350 дугаар тогтоолын дагуу, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг түүний хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдэх хүртэл бусдад худалдах, шилжүүлэхгүй байхаар заасан байдаг. Өөрөөр хэлбэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржид арилжаалагдаж эхлэх хүртэл бусдад шилжүүлэх, худалдах боломжгүй бөгөөд хөрөнгийн биржээр хувьцаа нь арилжаалж эхлэхийн тулд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нээлттэй хувьцаат компани хэлбэрээр Монголын хөрөнгийн биржид бүртгүүлсэн байх, Санхүүгийн зохицуулах хорооноос хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг өгсөн байх шаардлагатай юм.

Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь хаалттай хувьцаат компани буюу Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, хувьцааны арилжаа эхлээгүй байгаа тул иргэд өөрийн эзэмшлийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэх боломжгүй байна.



2019 ОНЫ ЦЭВЭР АШГААС ТАРААГДАХ НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Сим бол	Компанийн нэр	нийт хуваарилах ногдол ашиг /сая төгрөг/	Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг /төг/	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ATR	Атар-Өргөө ХК	60.9	350	-	2020.08.01	ҮЦТХТ
2	ADB	Ард кредит ББСБ ХК	1184.6	4.23	2020.04.08	2020.06 дотор	ҮЦТХТ
3	APU	АПУ ХК	75471.2	71	-	2020.08 дотор	ҮЦТХТ
4	TCK	Талх чихэр ХК	230.3	225	-	2020.06.20	ҮЦТХТ
5	AIC	Ард даатгал ХК	850	34	2020.04.09	2020.06 дотор	ҮЦТХТ
6	MBW	Монгол базальт ХК	255.6	4	2020.03.09	2020.06 дотор	ҮЦТХТ
7	BDS	Би ди сек ХК	136.9	10	2020.03.09	2020.12 дотор	ҮЦТХТ
8	NEH	Дархан нэхий ХК	232.1	210	2020.02.25	2020.09 хойш	ҮЦТХТ
9	LEND	ЛэндМН ББСБ ХК	1200	1.5	2020.02.25	2020.04 дотор	ҮЦТХТ
10	MNP	Монгол шуудан ХК	331	3.3	-	2020.05.01-с	ҮЦТХТ
11	HRD	Хүрд ХК	72.3	535	2020.03.02	2020.06 дотор	ҮЦТХТ
12	HRM	Гермес центр ХК	322	4.1	2020.02.28	2020.03.15	ҮЦТХТ
13	BUK	УБ-бүк ХК	526.2	4	-	2020.06.01	ҮЦТХТ
14	UBH	УБ хивс ХК	121.4	300	2020.03.06	2020.05.01-с	ҮЦТХТ
15	TAH	Тахь-ко ХК	128.5	108	-	2020.04 дотор	ҮЦТХТ
16	AARD	Ард санхүүгийн нэгдэл ХК	1000	34.95	2020.04.07	2020.04 дотор	ҮЦТХТ
17	MNDL	Мандал даатгал ХК	2490	4	-	2020.06 дотор	ҮЦТХТ
18	BNG	Баянгол ЗБ ХК	152.3	360	-	2020.09.01-с	ҮЦТХТ
19	MMX	Мах импекс ХК	456	120	-	2020.10.01-с	ҮЦТХТ
20	JTB	Женко тур бюро ХК	799.8	10	-	-	ҮЦТХТ
21	TEX	Техник импорт ХК	723.3	500	2020.03.11	2020.04.24-с	Компанийн
22	MFC	Монос хүнс ХК	408.8	1	-	2020.08.31-с	ҮЦТХТ
23	MCH	Монголын цахилгаан	25.8	1	-	2020.06.01-с	ҮЦТХТ
24	HUV	Хөвсгөл геологи	21.5	150	2020.04.03	2020.05.01-с	ҮЦТХТ
25	GTL	Гутал	2403.6	1520	2020.03.13	2020.05.05-с	ҮЦТХТ



ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХАЙГУУЛ, ӨРӨМДЛӨГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛСАН БАЙНА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD; MSE:ERDN) нь 2019 оны 4-р улиралд Алтан Нар, Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн хайгуул, өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцууллаа.

2019 оны 12-р сард хийсэн хайгуулын хөтөлбөрөөр Алтан Нард газрын дөт гүнд 50 г/т-оос дээш алтны агуулга бүхий хэд хэдэн интервал огтолж, эерэг үр дүн гарсан бөгөөд энэхүү үр дүнгээр Нээлтийн Бүсийн өндөр агуулгатай цөмийг өмнө зүгт тэлж, ирээдүйд Алтан Нарын нөөцөд эергээр нөлөөлж болох шинэ боломжуудыг нээсэн байна.

"МОНГОЛ БАЗАЛТ" ХК ОЛОН НИЙТЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн биржид 2018 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 6.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн "Монгол Базальт" ХК нь 2020 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар татан төвлөрүүлсэн нийт хөрөнгөнөөс 5.56 тэрбум төгрөгийг дараах байдлаар зарцуулсан тухай тайлан ирүүлсэн байна. Үүнд:

- Чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөл - 2.5 тэрбум төгрөг
- Цахилгааны дэд станц - 1.1 тэрбум төгрөг;
- Үйлдвэрийн барилга - 680.0 сая төгрөг;
- Үйлдвэрт ашиглах машин механизм - 330.0 сая төгрөг ;
- Базальт карьерийн аж ахуйн тоног төхөөрөмж - 40.9 сая төгрөг;
- Базальт карьерийн аж ахуйн машин механизм - 210.0 сая төгрөг;
- Түүхий эдийн 4 сарын нөөц - 599.0 сая төгрөг;

Урт хугацаат зээлийн эргэн төлөлт - 496.5 сая төгрөг.

"ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ СЭРГЭЭЛЭЭ

"Тандэм Инвест ББСБ" ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээх тухай Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 49 тоот албан шаардлагын дагуу арилжааг 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс нээлээ.

Тус компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан үнэт цаасны арилжааг 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн түр зогсоогоод байсан билээ.

"ЛЭНДМН ББСБ" ХК-ААС ИРҮҮЛСЭН МЭДЭГДЭЛ

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 3-р сарын 28-ны өдрийн 12:00 цагт хуралдуулахаар товлон шийдвэрлэсэн боловч Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2-р сарын 19-ний өдрийн ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулахаар болсон байна.

"АРД КРЕДИТ ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Ард Кредит ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар тус компанийн Гүйцэтгэх захирлаар Гэрэлтийн Тэлмэнг томилсон байна.

Г.Тэлмэн нь МУИС-ийн Олон Улсын Харилцааны Сургуулийг Олон улсын эдийн засгийн харилцааны мэргэжлээр төгссөн ба БНСУ-ын Сонкьонкван их сургуулийн Бизнесийн сургуульд Менежментийн шинжлэх ухааны Мастерын цол хамгаалжээ. Ажлын туршлагын хувьд БНСУ-ын LG, "Монгол шуудан" ХК зэрэг гадаад дотоодын компаниудад менежментийн болон гүйцэтгэх удирдлагын түвшинд 10 гаруй жил ажилласан байна.

компаниудад үүрэг болголоо. /Тогтоолыг энд дарж үзнэ үү/

Өмнөх хугацаанд ногдол ашгийг зарим хувьцаат компани ажлын байран дээрээ тарааж байсан ба энэ нь компаниас ногдол ашиг тараах бүрт хувьцаа эзэмшигч тухайн компани дээр очиж авах, зарим тохиолдолд мэдээлэл аваагүйгээс ногдол ашгаа огт аваагүй зэрэг хүндрэл, бэрхшээлтэй байсан. Ногдол ашгийг нэгдсэн байгууллагаар зохион байгуулалттай зуучлуулан тараадаг болсноор тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийн мөнгөн дүн төвлөрсөн хадгаламж дахь өөрийнх нь дансанд орох, төвлөрөх боломжтой болно.

Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигч ногдол ашгаа авахдаа брокерийн компанид хандан, мөнгө хүсэх өргөдлөө гаргаж өөрийн холбогдох банкны дансандаа шилжүүлэн, хаанаас ч авах боломжтой болох юм.

Санхүүгийн зохицуулах хорооноос энэ асуудлыг нарийвчлан тогтоож өгснөөр жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой бөгөөд уг шийдвэрийг биелүүлж ажиллахыг нийт ХК-ийн удирдлагуудад үүгээр анхааруулж байна.

"БАЯН-АЛДАР ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор "Баян-Алдар ББСБ" ХК-ийн оноосон нэрийг "Тандэм инвест ББСБ" ХК болгон өөрчилж, нийтэд санал болгон гаргасан нийт 19,922,679 ширхэг энгийн хувьцааг 50 хувааж, 996,133,950 ширхэг энгийн хувьцаа болгон бүртгэлд өөрчлөлт оруулсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN